

## НЭВТЭРХИЙ ТОЛЬ БҮТЭЭНЭ ГЭДЭГ НЭГ НАСНЫ ХӨДӨЛМӨР

Т.Баасансүрэн\*

*Ардын багш, МУСГЗ, доктор (PhD), профессор*

Түлхүүр үгс. Др, проф Л.Норовсүрэнгийн “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь” шинэ бүтээлийн үндсэн агуулга, зохиомж, бүтэц бүрэлдэхүүн. Шинэлэг талууд. Сэтгүүл зүйн онол, практикийн үндсэн ойлголт. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үүсч, хөгжиж төлөвшсөн түүх, өвөрмөц онцлог. Үе үеийн шилдэг төлөөлөгчдийн намтар, уран бүтээл, ур чадварын талаарх цэгцтэй цогц мэдээлэл. Нэвтэрхий толийн ололт амжилтууд ба зарим алдаа мадаг, цаашид анхаарах асуудал.

Сэтгүүл зүйн судлаач доктор, профессор Ломбын Норовсүрэнгийн “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь” шинэ бүтээл уншигчдын гарт очлоо. Норовсүрэн нь 64 ном хэвлүүлж, эрдэм шинжилгээний 67 өгүүлэл бичиж, 35 илтгэл хэлэлцүүлж, бусдын 51 ном бүтээлийг хянан тохиолдуулсан монголын сэтгүүл зүйн нэрд гарсан том эрдэмтэн. 2019 онд “Сэтгүүл зүй” хэмээх 21 боть зохиол хэвлүүлсэн нь Монгол Улсад шинжлэх ухааны нэг салбараар хамгийн олон боть ном бүтээсэн дээд амжилтыг тогтоосон байна.

Энэхүү мэргэжлийн мэдлэг мэдээлэл, МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхимд 40 жил ажиллахдаа хуримтлуулсан судлаачийн дадлага туршлагадаа дулдуйдаж байгаад “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-ийг бүтээжээ. Энэ бол хэр баргийн хүний барах, хийж чадах ажил биш ч Л.Норовсүрэн зориглон барьж аваад ард нь амжилттай гарсныг хараад үйлс зорилго нэгт эрдэм номын нөхрөөрөө бахархан омогших сэтгэл өөрийн эрхгүй төрөв.

Сэтгүүл зүйн салбарынхаа шат шатны сургалтад хамрагдаж байгаа оюутан, магистрант, докторант, мэргэжил дээшлүүлэгч, гадаад орнуудаас

уг мэргэжлээр Монголд ирж суралцагсад, сэтгүүл зүйн багш, судлаач шүүмжлэгчдэд тус болохыг хичээх үүднээс туурвисан “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь” бичигтээ зохиогч “Монголын үндэсний сэтгүүл зүйн арга туршлага, туурвил зүйн ололт амжилт хийгээд Өрнөдийн сэтгүүл зүйн онол, практикт тогтвортой өргөн хэрэглэгддэг тулгуур ухагдахуун, арга зүй, тогтсон нэр томъёо, ойлголтуудыг ашиглаж шинжлэх ухаан танин мэдэхүйн талыг голлосон шинэ мэдлэг мэдээллээр өргөтгөн баяжуулахын зэрэгцээ үндэсний сэтгүүлч эрдэмтдийн зөвлөгөө шүүмжлэлийг тусгаж, тэднээс хэрэглээнд багтай оруулж харьцангуй хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтуудыг ашигласан болно” гэжээ /Ломбын Норовсүрэн. “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”. УБ. 2025. Зохиогчийн үг. 4 дэх тал/.

Дотоод, гадаадын олон эрдэмтэн судлаачид, түүний дотор доктор, профессор М.Зулькафилийн “Сэтгүүл зүйн тайлбар толь” /2005/, доктор, дэд профессор Г.Мэндхүү, Т.Өнөрсайхан нарын “Телевизийн тухай А-Я хүртэл” /2014/, доктор, дэд профессор Д.Батжаргал, Г.Мэндхүү нарын “Радиоогийн тухай А-Я хүртэл” /2015/, доктор, профессор Э.Сонинтогосын эрхэлсэн “Телевиз VII” /2022/ зэрэг урьд өмнө нь энэ чиглэлээр гарсан бүтээлүүдийг ашигласнаа дурдаад миний “Нэвтэрхий толь бичгийн шинэлэг тал, гол ач холбогдол нь сэтгүүл зүйн онолын хатуу тогтоосон янз бүрийн ойлголт, томъёоллын ижил төстэй талыг нэгтгэх, зарчмын ялгаатай онцлогуудыг тайлбарлах, дэлхийн сэтгүүл зүйн онол, туршлагыг үндэсний сэтгүүл зүйд идээшүүлэх байр суурийг баримталсан болно” гэж онцолжээ /мөн толийн 5 дахь тал/.

Энэхүү толь бичигт сэтгүүл зүйн онол, парктиктай шууд холбогдох 1641 толгой үгийг Цагаан толгойн үсгийн дэс дараалалд оруулан байршуулж утга агуулгыг тайлбарлажээ. Түүний дотор 112 жилийн түүхтэй Монголын сэтгүүл зүйн үе үеийн түүхийг бүтээлцэж, өөрсдийн үйл ажиллагаа, уран нийтлэлүүдээрээ, эрдэм судлалын ажлаараа цаашдын хөгжил дэвшилд нь хувь нэмэр оруулан нөлөөлж түлхэц үзүүлсэн нэр бүхий 447 хүний амьдрал, уран бүтээлийн талаарх хураангуйлсан товч мэдээллийг багтаасан байна.

Сэтгүүл зүйн шинжлэх ухааны онол, практикийн үндсэн ойлголтыг уншигчдад өгч Монголд тогтмол хэвлэл, радио, телевиз, цахим мэдээлэл буюу уламжлалт болоод чөлөөт хэвлэл мэдээллийг хөгжүүлэхийн төлөө өөрсдийн амьдрал тэмцэл, оюун ухаанаа гүйцэд зориулагсдын талаарх хамгийн цэгцтэй мэдээллийг ийнхүү өөртөө агуулж байгаагаараа Ломбын Норовсүрэнгийн “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь” онцгойрон ялгарч байна. Өөрөөр хэлбэл урьд өмнө нь манай салбарт гарч байгаагүй жинтэй том бүтээл болж чаджээ.

**Сэтгүүл зүйн онолын тулгамдсан асуудлуудын талаар. Нэвтэрхий**

толь зохиогч Ломбын Норовсүрэн “Сэтгүүл зүй /Journalism/ гэдэг бол цаг үеийн чухал мэдээллийг цуглуулж, боловсруулж, зориулалтын техник хэрэгслээр олон нийтэд түгээх нийгэм-улс төр, мэдээллийн үйл ажиллагаа юм...

Сэтгүүл зүй нь шинжлэх ухаан ба практик үйл ажиллагааны салбар, түүнийг бүрдүүлдэг байгууллагуудын систем мөн...

Сэтгүүл зүй нь бас хэвийн ажиллахад шаардлагатай мэргэжлийн систем мөн...

Сэтгүүл зүй бол тусгай боловсрол, дадал чадвар эзэмшсэн хүмүүсийн бэлтгэдэг бүтээлүүдийн систем мөн...

Сэтгүүл зүй бол бас нийгмийн шинжлэх ухааны өвөрмөц салбар, сэтгүүл зүйн мэргэжил эзэмшүүлэх судлагдахууны нийлбэр цогц мөн” гэжээ. /Ломбын Норовсүрэн “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь” УБ. 2025. 388-389 дэх тал/.

Эл тодорхойлолт тайлбарлалаас сэтгүүл зүй гэдэг нь нийгмийн өвөрмөц үзэгдэл, хүний нийгэмд зайлшгүй хэрэгтэй үйл ажиллагаа, тусгай сургалтаар бэлтгэгдэж мэргэшсэн хүмүүс хэвлэл мэдээллийн редакци, мэдээллийн агентлаг, радио болоод телевизийн хамтлаг зэрэг мэргэжлийн нарийн зохион байгуулалтад орсон нийгмийн чухал институт болох нь ойлгогдоно.

“Иргэний сэтгүүл зүй /Civic journalism/. Амьдралдаа тохиолдсон чухал асуудлыг мэдээлэхэд идвэхтэй оролцдог сонгогчдын сэтгүүл зүйн үйл ажиллагааг иргэний сэтгүүл зүй гэдэг. Түүнийг заримдаа олон нийтийн сэтгүүл зүй гэж нэрлэх нь ч бий. Америкийн үндэсний бэлэг тэмдэг, иргэд болоод нийгмийн мөн чанар болсон ардчиллын зэврэлтийн эсрэг нигүүлсэнгүйн Пью сангийн санаачилга, дэмжлэгээр 1993 онд иргэний сэтгүүл зүйн төвийг анх байгуулжээ...

Иргэний сэтгүүл зүй нь нэг талаас хэвлэл мэдээллийн хэрэгслээс амьдралын гүн рүү тавих анхаарлаа нэмэгдүүлж, жирийн иргэдийн ахуй амьдралыг түлхүү тусгах үйл ажиллагаа, нөгөө талаас хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд иргэдийг өргөнөөр татан оролцуулж, тэднээс ахуй амьдралынхаа тулгамдсан асуудлыг сөхөн тавьж шийдвэрлэхэд нь мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид туслах явдал юм. Энэ утгаараа мэргэжлийн сэтгүүл зүй, олон нийтийн сэтгүүл зүйн зохистой хослол болж хөгжих ирээдүйтэй юм” / мөн толийн 191 дэх тал/.

Эндээс мэргэжлийн сэтгүүл зүй нь нийгмийн төлөө үйлчилж, хүн ардынхаа дуу хоолой болж, тэдний мэдэх эрхийг хэрэгжүүлдэг, эл үйл ажиллагаандаа иргэдийг өөрсдийг нь татан оролцуулвал илүү хүч нэмэгддэг

болох нь тод харагдаж байгаа юм.

Зохиогч энэ мэтээр сэтгүүл зүйн үндсэн зарчим, үүрэг зорилт зэргийг тал бүрээс нь аль болохоор ойлгомжтойгоор багтааж багцалж оруулахыг эрмэлзсэн байна. Жишээлбэл сэтгүүл зүйн онолын агуулга ба хэлбэр, арга зүйн асуудлыг хөндөж **“Агуулга ба хэлбэр” /Content and form/**. Сэтгүүл зүйн онол арга зүйн асуудлыг авч үзэх үед агуулга, хэлбэрийн тухай ойлголт зайлшгүй гарч ирдэг. Учир нь агуулга ба хэлбэр бол бүтээл туурвил биежих үндсэн нөхцөл мөн...

Агуулга нь тухайн юмыг бүрдүүлж байгаа элементүүдийн цогц, тэдгээрийн хэлхээ холбоо, ерөнхий байдал, хандлага бол, хэлбэр нь тодорхой зохион байгуулалтад ороогүй, гадаад дүр төрхийг илэрхийлдэг...

Сэтгүүл зүйн туурвилын агуулгыг үйл явдал, баримт, сэдэв, зохиогчийн дэвшүүлж буй үзэл санаа, дүгнэлт, зөвлөмж элементүүд бүрдүүлдэг бол, хэлбэрийг бүрдүүлэх элементүүд нь бичлэгийн төрөл, зүйл, зохиомж, зохиогчийн хэл найруулга, өнгө аяс зэрэг болно” /мөн толийн 46 дахь тал/.

Улмаар **Агуулга, хэлбэрийн нэгдэл /Combination of content and form/**. Агуулга, хэлбэр хоёр бол нэг юмны хоёр тал, тухайн юмыг бүрдүүлэх үндсэн нөхцөл мөн. Агуулгагүй хэлбэр, хэлбэргүй агуулга гэж байдаггүй гэж шинжлэх ухаан нотолдог...

Агуулга, хэлбэрийн нэгдэл гэдэг бол тэдгээрийн зохистой харьцаа юм” хэмээжээ /мөн толийн 46 дахь тал/.

Залгуулаад сэтгүүл зүйн арга зүй хэмээх ухагдахууныг хөндөж **“Арга зүй” /Methodology/...** Сэтгүүл зүйн ухааны үүднээс авч үзвэл арга зүй нь уран бүтээлийн чанар, үр нөлөөг сайжруулах үйл ажиллагааны мөн чанар, систем, арга замын тухай мэдлэгийн нийлбэр юм... Түүний цөм нь сэтгүүлчийн баримталдаг философи, өөрөөр хэлбэл нийгмийн хөгжил, үйл ажиллагаанд үндэслэгддэг хууль, зүй тогтлуудын тухай төсөөллийн систем юм” гэсэн байна /мөн толийн 58 дахь тал/.

Аливаа шинжлэх ухааны эцсийн зорилго бол үр дүнд хүрэх явдал юм. Тийм ч учраас сэтгүүл зүйд үр нөлөө, үр ашгийг онцгойлон авч үздэг. Зохиогч үүнд өөрийн анхаарлыг хандуулж олон талаас нь уг ойлголтыг тодотгохыг чармайжээ.

**“Нийтлэлийн үр нөлөө, үр ашиг /Efficiency and Benefits of Publication/**. Үр нөлөө, үр ашиг гэдэг нь сэтгүүл зүйн онолын язгуур ойлголтуудын нэг юм. Учир нь сэтгүүл зүйн эцсийн зорилго бол үр дүнд хүрэх явдал юм...

Нийтлэлийн бүтээл олон нийтийн ухамсарт нөлөөлж, тэдний үзэл бодол, үйл ажиллагаанд тус хүргэх үйл явц нь нөлөө, үр нөлөө, үр ашиг

гэсэн хоорондоо салшгүй холбоотой бөгөөд өсөх дарааллаар хэрэгждэг...

Үр ашгийг практикийн үр ашиг, оюун санааны үр ашиг гэж ялгадаг. Нийтлэлд дэвшүүлсэн санааг хэрэгжүүлснээр байгууллага, хүмүүсийн ажилд гарсан амжилт ололтыг практикийн үр ашиг, харин тухайн нийтлэлийг уншсан хүний үзэл бодол, мэдлэг чадварт гарсан өөрчлөлтийг оюуны үр ашиг гэдэг. Үүнээс гадна үр нөлөө, үр ашгийг өргөн ба явцуу хүрээний гэж ангилдаг” /мөн толийн 278-279 дэх тал/.

“Сэтгүүл зүйн зарчим” /Principles of Journalism/. Зарчим гэдэг нь латин хэлний principium-“эх”, “үндэс”, “үйлдэл” гэсэн утгатай үгнээс гаралтай нэр томъёо юм... Сэтгүүл зүйн зарчим гэдэг бол сэтгүүл зүйн бүтээлийн онол, уран сайхны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны арга зүйн үндэс, жанжин журам /шугам гэж би ойлгов Т.Б/ мөн. Түүнчлэн сэтгүүл зүйн мэдлэгийн системчлэгдсэн хуримтлал, үйл ажиллагааны уг үндэс болж чадахуйц түгээмэл, харьцангуй тогтвортой мэдлэгийн төвлөрсөн илэрхийлэл мөн” /мөн толийн 392 дахь тал/.

Ихэнх судлаачид эдгээр утга агуулгатай санал нэгдэх буй заа. Яагаад гэвэл энэ нь манайд төдийгүй гадаадын олон улс орны сэтгүүл зүйн онол, практикт нэгэнт хэвшиж тогтсон, нэг их маргаан мэтгэлцээн дагуулдаггүй сэдэв юм. Харин Л.Норовсүрэнгийн “Сэтгүүл зүйн зарчим” хэмээх ойлголт дээр хэрэглэсэн журам гэдэг үгийг би хувьдаа шугам гэдэг утгаар ойлгож байна. Журам, шугам хэмээх хоёр үг утга агуулгын хувьд ихээхэн том, бүр тэнгэр газар шиг ялгаатай учир үүнийг техникийн алдаа буй заа гэж үзлээ. Зарчим дээр жанжин шугам гэвэл илүү нийцтэй, журам гэхээр шол хийж сулраад, ач холбогдол нь алдарч багасаад явчихаж байгаа юм.

Нэвтэрхий толийн зохиогч **Либертари онолыг** ихэд дэлгэрэнгүйгээр туйлын ойлгомжтойгоор бичиж тайлбарласныг сайшааж байна.

Олон хүний сонирхлыг татдаг хэвлэл мэдээллийн дөрвөн онолын талаарх мэдээлэл ч Л.Норовсүрэнгийн “Нэвтэрхий толь”-д дэлгэрэнгүй оржээ. Судлаачид тэдгээрийг авторитари, либертари, нийгмийн хариуцлагын, зөвлөлт засаглалын он жилүүдийн үеийн коммунист онол гэж ялгадгыг зохиогч тэмдэглээд “Авторитари үзэл онол нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл зөвхөн хаан, фюрер, эзэн, төр засгийн өмнө хариуцлагыг хүлээдгийг тогтоож өгсөн бол, хэвлэлийн эрх чөлөөний буюу либертари онол нь тийм хараат байдал ба хэвлэл төрийн зэвсэг байх ёстой гэсэн үзэл баримтлалыг үгүйсгэж, хэвлэл төрийн зүгээс тавих аливаа хяналтаас ангид чөлөөтэй байхын хамт төрийн гурван өндөрлөгөөс хараат бус байж, төр засгийг хянах замаар “дөрөв дэх засаглал”-ын үүргээ гүйцэтгэдэг гэж үздэг байна.

Гэтэл нийгмийн хариуцлагын онол нь либертари чиглэлийг хэвлэл мэдээллийн төвлөрөл, монополчлолын шинэ нөхцөлд тохируулан

хөгжүүлсэн бөгөөд гол санаа нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн эрх ашгийг харгалзан үзсэний үндсэн дээр эздээс тодорхой хэмжээгээр хараат бус, бие даасан байдалд ажиллах ёстой гэж үзсэн юм. Зөвлөлтийн коммунист онол нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, коммунист намын зэвсэг, мэдээллийн хэрэгсэл байх ёстой гэсэн авторитари үзэл баримтлалын нэг хувилбар юм” гэжээ /мөн толийн 544-545 дахь тал, “Хэвлэл мэдээллийн дөрвөн онол” толгойн гарчигт бичвэрийг харна уу/.

Монголд хэвлэл мэдээллийн төвлөрөл явагдаж, олонхи хувийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл цөөхөн тооны эздийн мэдэлд монополчлогдох үйл явц хүчтэй өрнөж буй өнөө цаг үед сэтгүүлчдээс нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага улам өндөржиж чөлөөт хэвлэл мэдээллийн үзэл санаагаа тодотгож ухамсарлах явдал чухлаар тавигдаж байгаа билээ. Энэ нь ардчилсан нийгмийн нэг гол үнэт зүйл мөн тул Монголын сэтгүүлчид түүнийг мартаж болохгүй.

Ардчилсан нийгэмд иргэдийн мэдэх эрх тэргүүн зэрэгт тавигдаж байдаг бөгөөд сэтгүүлчид ард түмнийхээ тэрхүү эрхэд үйлчилж, бүхнийг тэдний хяналтад оруулж “дөрөв дэх засаглал”-ынхаа үүргийг биелүүлж байдаг. Энэ эрх чөлөө алдагдвал нийгэм харанхуйлна.

Үүнтэй холбогдуулж Л.Норовсүрэнгийн “Нэвтэрхий толь” дахь **“Чимээгүйн эргүүлэг онол”**-ыг уншигчиддаа зориуд сонирхуулья. Зохиогч “Энэ онолыг 1974 онд Германы улс төр судлаач Элизабет Ноэль-Нейман дэвшүүлжээ. Тэрээр уг онолоороо олон нийтийн санаа бодол бүрэлдэн төлөвших жам хийгээд бусдаас тусгаарлагдахаас айх нь маргаантай сэдвээр үзэл бодлоо илэрхийлэхэд саад болдгийн учрыг тайлбарласан юм. Тэрээр хүн өөрийнхөө үзэл бодлыг олонхынхоос өөр гэж үзвэл дуугуй байхыг эрхэмлэдэг. Эсвэл үзэл бодлоосоо татгалзаж олонхын санаа бодлыг хүлээн зөвшөөрөх болдог. Ингэснээр нийгэмд цөөнхийн дуу хоолой дарагдан, олонхын үзэл бодол хүчээ авч нийгмийг “чимээгүйн эргүүлэг”-г хөтөлдөг гэж үзсэн. Түүнийгээ Адольф Гитлер Германы нийгэмд ноёрхлоо тогтоох үед жүд үндэстнүүд нийгмээс тусгаарлагдахаас айж чимээгүй болсон баримтаар тайлбарлажээ...

Тиймээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлдэг гэж үзэхийн зэрэгцээ бас түүнийг шүүмжлэх онолын уг сурвалж болдог байна. “Чимээгүйн эргүүлэг” онол нь нийгмийн цөөнхийн дуу хоолойг хөгжүүлж, тэдний оролцоог хангахыг чухалчилдаг шинжээрээ социологич, олон нийтийн харилцаа судлаачдын анхаарлыг ихээр татаж, улам нарийсан хөгжсөөр байгаа юм” гэжээ /мөн толийн 584-585 дахь тал/.

Сүүлийн гучин таван жилд албан тушаал, эрх мэдэл, чухал мэдээлэлд ойр буй давуу талаа ашиглан хөлжиж баяжиж төрөөс төрсөн манай тэрбумтнууд

үйл ажиллагаагаа зүйл бүрээр зөвтгөн өөрсдийгөө өглөө үдэшгүй магтуулж нийгмийн сэтгэл зүйг залж залуурдах болсныг бид мэднэ. Ийм нөхцөлд “дөрөв дэх засаглал”-ынхан шударга зарчимч шүүмжлэл нийгэмд ус агаар адил хэрэгтэйг ямагт санаж бузар булай бүхэнтэй эвлэршгүй тэмцэж аюулын харанга дэлдэж байх үүрэгтэй. Сэтгүүлч бүр “чимээгүйн эргүүлэг” онолыг марталгүй үе үе санаж байхад ер илүүдэхгүй. Энэ бол хүн төрөлхтөний өнгөрсөн түүхээр нотлогдсон чухал ач холбогдолтой дуут дохио юм.

Сэтгүүл зүйн шүүмж судлал нь хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа, нийт сэтгүүлчдийн уран бүтээлийн ололт амжилт, алдаа дутагдлыг тухай бүр хэлж тэмдэглэж анхааруулан сэрэмжлүүлж тус нэмэр үзүүлэх үндсэн үүрэгтэй байдаг. Үүнтэй холбоотой цөөнгүй утга агуулга “Нэвтэрхий толь”-д байна. Тухайлбал “**Задлан шинжлэх арга**” /Analytical method/. Зохиол, нийтлэлийн мөн чанарыг тодорхойлон гаргах уламжлалт, түгээмэл арга юм. Зохиол, нийтлэлийг задлан шинжлэх нь судлагчийн онолын байр суурь, дадал дүй, билгийн хараа, ажлын туршлага, авьяас чадвартай холбоотойн дээр бусад олон зүйлийн арга, зарчим, үзэл баримтлалын харилцан үйлчлэлийн үндсэн дээр судлагдахууныхаа онцлог шинж, мөн чанарыг нээн гаргах үйл явц мөн.

Задлан шинжлэх үйл явц нь задлах, харьцуулах, нэгтгэх гэсэн гурван гол аргын харилцан үйлчлэлийн үр дүнд хэрэгждэг. Өөрөөр хэлбэл тодорхой нэг үзэгдлийг задлан шинжлэх замаар олон зүйлийн ерөнхий шинж, түгээмэл зүй тогтлыг тогтоож баталгаа, дүгнэлт гаргах арга юм. Энэ аргыг сэтгүүл зүйн шүүмж судлалд өргөн хэрэглэдэг” /мөн толийн 155-156 дахь тал/.

Энэ мэтээр сэтгүүл зүйн онолын олон арван үндсэн гол асуудлаарх тойм тодорхойлолтыг Л.Норовсүрэн өөрийн “Нэвтэрхий толь”-д тусгаж чадсан байна. Бүгдийг тоочих боломжгүй бөгөөд дээр дурьдсан санаанууд дээр жижиг гэлтгүй ганц нэг салаа мөчрийг нэмж сонирхуулахад “**Мэдээллийн цөлжилт**” /News desert/. Мэдээллийн цөлжилт гэдэг нь иргэд өөрсөдөө хэрэгтэй мэдээлэл олж авах боломж хязгаарлагдмал буюу огт боломжгүй байхыг хэлнэ...

Мэдээллийн цөлжилт нь орон нутгийн сонин, радио, телевизийн сувгууд санхүүгийн бэрхшээлтэй тулгарч үйл ажиллагаа нь доголдох, хаагдах, эсвэл бүр тийм хэрэгслүүдийг үүсгэн байгуулах боломжгүй байдлаас үүсдэг” гэх буюу эсвэл “**Мэдээллийн цунами**” /News tsunami/. XXI зууныг мэдээллийн зуун гэж нэрлэх болсон. Үнэхээр ч энэ зууны мэдээллийн урсгал нь асар том давалгаа үүсгэдэг байгалийн хүчтэй үзэгдлийн нэгэн адил нийгмийг мэдээллийн давалгаанд живүүлэх болсон юм. Мэдээллийн гэнэтийн түрлэгээр тоолж баршгүй олон тооны мэдээлэл урсан орж ирж, тэдгээрийг хүлээн авч, эрэмбэлж, боловсруулж, амьдрал ахуйд хэрэглэхэд ойлгомжгүй

байдал үүсэхийг мэдээллийн цунами гэх болжээ” /мөн толийн 259 дэх тал/ гэх зэргээр шинэ сэргэг сонин хачин мэдээлэл ойлголтоор нэвтэрхий толио шигтгэж баяжуулж өгчээ.

Үүн дээр “**Мэдээллийн эмгэг**” /Information disorder/. Мэдээллийн эмгэг гэдэг нь худал, ташаа, буруу, мушгиж гуйвуулсан, төөрөгдүүлсэн, зохиомол мэдээлэл ашиглах, түгээхийг хэлдэг” /мөн толийн 259 дэх тал/ гээд худал мэдээлэл, мушгин гуйвуулсан мэдээлэл гэх зэргээр тус бүрд нь ялгаж салгаж тайлбарлажээ.

“Мэдээллийн эмгэг нь мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг бууруулж, нийгэм, улс төрийн хуваагдлыг хурцатгаж, сонгуулийн үр дүнд нөлөөлөх зэрэг ноцтой үр дагаварт хүргэх аюултай юм” /мөн толийн 260 дахь тал/ гэж онцгойлон анхааруулсан байна.

Сэтгүүл зүйн онолын эдгээр тулгуур ойлголтуудаас гадна та бидний өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлагатай онол-практикийн хосолмол шинжтэй мэдээлэл, тэрчлэн цэвэр практик асуудлуудаар ч Л.Норовсүрэнгийн “Нэвтэрхий толь” элбэг баян болсныг олзуурхан тэмдэглэе. Сэтгүүл зүйн чиглэлээр лекц уншиж, семинар удирддаг их, дээд сургуулийн багш нар, курсын болоод дипломын ажил бичиж буй оюутнууд, магистрантур ба докторантурын сургалтад хамрагдагсдын хувьд ширээний ном нь болохоор аж. Заримынх нь зах зухаас нь дурдая.

**Сэтгүүл зүйн практик үйл ажиллагааны талаар.** “**Баримт** /Fact/. Энэ нэр томъёо нь латин хэлний factum”- “бүтээгдсэн”, “хийгдсэн” гэх утгатай үгнээс гаралтай аж. Баримт нь бодит байдал ба хүний танин мэдэхүйн тодорхой объект юм. Танин мэдэхүйн онолын үүднээс энэ ерөнхий тодорхойлолт нь сэтгүүл зүйн ухаанд баримтыг ойлгоход арга зүйн ач холбогдолтой юм” /мөн толийн 82 дахь тал/ гэж зохиогч тэмдэглэн, сэтгүүлчдийн мэдээллийн амин сүнс болох баримтын хэд хэдэн утгыг тайлбарлаад “хамгийн найдвартай баримт бол сэтгүүлчдийн өөрийн гараар барьж, нүдээр үзсэн бодит байдал мөн” /мөн толийн 83 дахь тал/ гэжээ. Нүд үнэн, чих худлаа шүү л гэсэн байна. Манай залуу сэтгүүлчдийн зүгээс үйл ажиллагаандаа үе үе гаргачих гээд байдаг түгээмэл алдаа бол сургаар сонссон зүйлд сохроор итгэж хөтлөгдчих гээд байдаг явдал юм.

**Баримтыг шалгах, баримт-уран сайхны харьцааг тохируулахад** юуг анхаарвал зохилтойг “Тоо баримт бол зохиогчийн өгүүлж байгаа санааг нотлох гол зүйл юм. Огт байхгүй бол үгүйлэгдэнэ. Харин хэт олон тоо баримт, нэр дурдвал уншигчийн анхаарлыг сарниулдаг” /мөн толийн Баримтыг шалгах, 84 дэх тал/, “Нийтлэлийн бүтээлд уран сайхны хийсвэрлэлийн аргыг хэтрүүлснээс бодит байдлаас холдож, үнэмшилгүй болдог бол, баримтыг хэт шүтсэнээс болж амт шимтгүй хуурай өгүүлэмж

болох сөрөг талтай” /мөн толийн Баримт- уран сайхны харьцаа, 85 дахь тал/ гэж Л.Норовсүрэн зөвлөж байна. Энэ бол сэтгүүлч нэг бүрийн ямагт бодож санаж явах ёстой зүйл мөн билээ.

Доктор Л.Норовсүрэн өөрийн толийн **“Нотолгоо”** хэмээх толгойн үсгийн тодорхойлолтдоо сэтгүүлчийн үндсэн зорилго бол үнэн бодитой мэдээлэл түгээх явдал. Баримтаа зөв цуглуулж, түүнийхээ үнэн зөвийг нотолж чаддаг байх ёстой гээд “Нотолгоо нь ямар нэг бодол санааны үнэн магадтай болохыг түүнтэй холбоотой өөр нэг юмуу, хэд хэдэн баримтаар тогтоох үйл явц юм. Аливаа юмны үнэн магадтайн нотолгоо нь сэдэв, үндэслэгээ, хэлбэр зэргийг шинжилсний үр дүн байдаг. Сэдэв бол сэтгүүлчийн нотлох ёстой зүйл, үнэлгээ нь сэдвийг нотлоход ашиглаж байгаа баримтууд, харин нотолгоо нь сэдэв, үндэслэгээ хоёрыг холбон шинжилсний үр дүн юм” /мөн толийн 282 дахь тал/ гэжээ.

Сүүлийн гучаад жилийн Монгол дахь практикаас харахад ямар нэгэн хэл аманд өртсөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нэр бүхий сэтгүүлчид өөрсдийн шүтэл үлээсэн шүүмжлэлээ бүрэн гүйцэд нотолж чадахгүй бүдрэх нь цөөнгүй харагддаг. Тийм учраас баримтын үнэн зөв, магадтай болохыг хөдөлшгүйгээр нотолж чаддаг урлагийг сайтар эзэмших нь тулгамдсан зорилтын нэг болоод байгаа юм.

Доктор Л.Норовсүрэн нь сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлээр эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтэн гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Энэ нь ч “нэвтэрхий толь”-иос нэвт шувт мэдрэгдэж байна. Жишээ нь **“Бичвар сүлэлдэл”** /intertextuality/... Зохиол, нийтлэл үнэ цэнтэй, сонирхолтой, амьд дүрслэлтэй болох үндэс нь ерөнхий бичвэрийн дотор өөр бусад бичил бичвэрүүд татагдаж, өөр хоорондоо сүлэлдэх байдал буюу интертекстүүд өөр өөрийн шаардлагатай хэсгүүдэд байршиж, нийлэгжсэн байдлаар оршихыг бичвэр сүлэлдэл гэдэг” /мөн толийн Бичвэр сүлэлдэл, 92 дахь тал/ гэжээ.

Өнгөрсөн зууны ерээд онд Монголд нэг нийгэм нөгөөгөөр солигдох шилжилтийн үйл явц өрнөх үеэр манай сэтгүүл зүйн зарим хэт мэдэмхийрэгчид сэтгүүл зүйд бичлэгийн төрөл, зүйл гэж байхгүй, энэ бол өнгөрсөн нийгмийн хоцрогдол. Мэдээ, ярилцлага хоёр л үлдсэн байж магадгүй гэх нь холгүй донгодож байсныг мартаагүй байна. Сэтгүүл зүйд бичлэгийн төрөл, зүйл хэмээх хэвшиж тогтсон бичлэгийн арга, хэлбэр байсаар ирсэн бөгөөд ирээдүйд ч байх болно. Тэдгээр төрөл, зүйлийн зарим элементүүд бие биесийг баяжуулж, харилцан нөлөөлж, нэг нэгэндээ нэвчин нийлэгжиж уусах үзэгдэл бол өөр асуудал юм. Чадалтай сайн сэтгүүлчид сэтгүүл зүйн бүх төрөл, зүйлээр нийтлэлээ бүтээж чаддаг, тэдгээрийг сүлэлдүүлэх арга зүйг ч чадмаг эзэмшсэн байдгийг манай өнгөрсөн практик бэлхнээ харуулж байгаа юм. Харин Бямбын Ринченгийн

“Их говийн зоригтон хүмүүс”, Мөнгөний Бизьяагийн “Өвлийн нүүдэл”, Ш. Цэрэнпилийн “Хэнээт” шиг бичлэгийн тодорхой нэг жанраар уран сайхны өндөр түвшинд товойлгон урлаж бүтээж чаддаг нь харьцангуй цөөрсөн гэдэгтэй бол санал нийлж болох юм.

“**Бичлэгийн төрөл зүйл**” /Genre/. Төрөл, зүйл бол уран сайхны бүтээлийн тогтворжсон хэлбэр мөн... Сэтгүүл зүйн бичлэгийг мэдээллийн төрөл /мэдээ, тайлан, ярилцлага, сурвалжлага, тойм/, шинжлэлт төрөл /өгүүлэл, хэвлэлийн тойм, тайлбар, шүүмж, төрөгдөл/, нийтлэл -уран сайхны төрөл /найруулал, шог найруулал, улс төрийн шог, уран нийтлэл/ гэсэн үндсэн гурван төрөлд ангилдаг.

Эдгээр ангилалд багтахгүй байгаа телевизийн хөтөлбөр, оршуулгын бичиг, социологийн судалгааны дүн, рейтинг, мониторинг, зөвлөгөө, мэдэгдэл, зурхай, анкет, шог яриа, үгийн сүлжээ гэх мэт бичил нийтлэлийг бичлэгийн жижиг зүйл гэдэг. Үүнээс үзвэл нийтэлж, нэвтрүүлж байгаа бичлэгийг илүү адил төстэй шинжүүдээр нь бүлэглэснийг бичлэгийн **төрөл**, нэг төрөлд багтаж байгаа тусгай бичлэгийг **зүйл**, зүйлийн доторх бичил ангиллыг **хэлбэр** хэмээн үзнэ. Жишээлбэл сурвалжлага бол өөрөө мэдээллийн төрөлд багтдаг зүйл бөгөөд дотроо мэдээлсэн, үйл явдлын, үйлдвэрлэлийн, асуудал дэвшүүлсэн гэх мэт хэлбэртэй байдаг” /мөн толийн 93 дахь тал/ гэх зэргээр туйлын ойлгомжтойгоор тайлбарлажээ.

Мэргэжлийн редакци бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, нийт уран бүтээлчдийн хувьд редакторын гүйцэтгэх үүрэг үнэхээр онцгой ач холбогдолтой байдаг юм. Өндөр зэрэглэлийн мэргэшсэн редактор нь тухайн хамт олны хувьд ч, тодорхой уран бүтээлчдийн хувьд ч тэр юугаар ч сольж орлуулашгүй үнэт эрдэнэ, нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга, агуулгыг чанаржуулагч гол зөвлөгч нь билээ. Хэр баргийн сэтгүүлч шууд редактораар томилогдон ажиллаж чадахгүй. Олон жилийн хөдөлмөр, хур их туршлага дадлага шаардагдана. Редактор хүн өөрөө чадамгай уран бүтээлч, тодорч товойсон сод сэтгүүлч байх ёстой. Бусдын бүтээлд эхийн сэтгэлээр хандаж уншиж зөвлөж, засаж сайжруулан чанаржуулна гэдэг хүн чанарыг нэхсэн хүнд хөдөлмөр. Бахархалтай нь тийм бичиг номын нэртэй том гүүшүүд, эрин цагийг эзэгнэсэн гайхамшигт редакторууд монголын утга зохиол, сэтгүүл зүйн түүхэнд нэг биш нэг хэсгээрээ байсаар иржээ.

Далд фронтын дайчид болох үгийн мастер редакторууд бол үнэн чанартаа тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нүүр царайг тодорхойлогчид, нийтлэл нэвтрүүлгийн бодлогыг боловсруулж, залж чиглүүлэгчид, жанжин штабын толгойлогч удирдагчид байдаг юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл амжилттайгаар оршин тогтнох эсэх нь чадварлаг туршлагатай редактораас шууд хамааралтай байдаг. АНУ-ын нэг хэвлэл редакторын орон тоогоо хэрэггүй, илүүдсэн орон тоо гэж устгаад сүйрэх дөхөж ахин сэргээсэн

гашуун сургамж ч бий.

Редакторын ажлын чухлыг ойлгож мэддэг доктор Л.Норовсүрэн өөрийн нэвтэрхий тольдоо **Редактор, Редакторлах арга зүй, Редакторлах ажлын үе шат, Редакторлах зүйн зарчим, Редакторлах зүйн онол, дадлага, Редакторын ур чадвар, Редакторын үг, Редакци, Редакцийн зөвлөл, Редакцийн хараат бус байдал** гэх зэргээр толгойлон гарчиглаж байгаад тоймлон тодорхойлж нэг бүрчлэн өгүүлсэн байна. Ач холбогдлыг нь үнэлж зай талбай харамласангүй.

**Редактор /Editor/.** Энэ нь латины Redigo –“хянах”, “засах”, “залруулах” гэсэн утгатай үгнээс гаралтай нэр томъёо юм... ном хэвлэлийн агуулга, хэл найруулгыг хянан засах, зохиогчид зөвлөхөөр итгэмжлэгдэн томилогдсон хүнийг тухайн бүтээлийн редактор гэдэг. Мөн үүрэг хүлээсэн редакторыг хянан тохиолдуулагч, ариутган шүүгч, хянан найруулагч гэх мэтээр нэрлэх болсон юм...

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд байнга ажиллаж алба, хэлтэс, тасгийг удирдан, хариуцсан чиглэлийнхээ мэдээ материалыг эцэслэн хянадаг хүнийг мөн редактор гэдэг. Ялангуяа радио, телевизийн салбарт тодорхой чиглэлийн мэдээ материалыг бэлтгэж гаршсан сэтгүүлч мэргэжилтнийг редактор гэж нэрлэх нь түгээмэл байдаг.

Товчоор хэлбэл редактор нь ном зохиол, нийтлэлд чанарын хяналт хийдэг хүн юм... редактор гэдэг бол улс төрийн өндөр мэдрэмжтэй, аливаа асуудалд буурь суурьтай ханддаг, гуйвж дайвдаггүй, утга зохиолын өндөр боловсролтой, авьяастай, бичиж найруулах чадвартай мэргэжилтний хийдэг ажил мөн” /мөн толийн 344-345 дахь тал/

**Редакторлах арга зүй /Methods of editing/.** Ном зохиол, хэвлэл мэдээллийн газарт эх бичвэрийг редакторлахад уншиж засах, хураангуйлан засах, боловсруулж засах, өөрчлөн засах гэсэн дөрвөн аргыг хэрэглэдэг” / мөн толийн 344 дэх тал/.

**Редакторлах ажлын үе шат /Steps of Editing/.** Эх бичвэрийг редакторлах ажлын олон жилийн туршлага хуримтлагдсаар дараах үе шатуудыг хэвлэлийн газрын практикт нэгэнт тогтоожээ. Үүнд: 1. Эх бичвэрийн талбайд хийх тэмдэглэл, 2. Гарчигт хийх засвар, 3. Зохиомжийг сайжруулах засвар, 4. Баримтыг магадлах үе шат болно” /мөн толийн 345 дахь тал/

**Редакторлах ур чадвар /Editor’s skills/.** Үйлдвэр соёлын аль ч салбарт тухайн салбарын тэргүүлэгч гол мэргэжил гэж байдаг. Түүнтэй адил хэвлэл мэдээллийн газруудын тэргүүлэгч мэргэжил нь редактор юм. Тэр нь зохиогчийн анхны туслагч, ном хэвлэлийн бүтээгдэхүүний эхний уншигч,

шүүмжлэгч болдог. Түүнчлэн ном хэвлэлийн хувь заяаг тодорхойлогч, түүний бүхий л үйл ажиллагааг чиглүүлэн хөтлөгч болдог. Энэ шинжээрээ редакторын мэргэжил нь олон талтай, нарийн төвөгтэй, илүү хүнд хэцүү ажил юм” /мөн толийн 347 дахь тал/.

Энэ мэтээр Нэвтэрхий толийн зохиогч хэвлэл мэдээллийн салбар дахь тэргүүлэгч чухал мэргэжлүүд, мэргэжилтнүүдийг тоймч, олон улсын тоймч гэх зэргээр оноон нэрлэж, тэдгээрийн нэрд гарсан төлөөлөгчийг нэр заан дурджээ.

**Олон улсын тоймч /Observer/.** Олон улсад болж байгаа улс төр, нийгэм, эдийн засгийн үйл явдлыг судлан шинжилж, нэгтгэн дүгнээд хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлдэг уран бүтээлчийг олон улсын тоймч гэдэг... Манай сэтгүүлчдийн дотроос олон улсын амьдралыг дагнан судалж сайн тойм хийдэг уран бүтээлчид олон байв. Б.Дүгэр, Д.Базарваань, Ц.Мөнхбаатар, Р.Даваажав, С.Нэмэхбаяр, С.Чимэддамба, Б.Дашзэвэг зэрэг олон улсын тоймчид төрж гарсан юм” /мөн толийн 306 дахь тал/.

**Тойм /Review/.** Тодорхой хугацаанд болж өнгөрсөн үйл явдал, үзэгдлүүдийг эсвэл тухайлсан нэг салбар, сэдэв, асуудлыг сонгон авч баримтуудыг ангилж, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар тайлбарладаг сэтгүүл зүйн шинжлэлт бичлэгийн зүйлийг тойм гэдэг...

Туршлагаас харахад тоймчид гол төлөв тодорхой нэг сэдвээр мэргэшсэн, туршлагатай, хэлний өндөр мэдлэгтэй, гол төлөв хос мэргэжилтэй, эрдэмтэн хүмүүс байдаг. ОХУ-ын тоймч В.Зорин түүхийн шинжлэх ухааны доктор, профессор, А.В. Афанасьев эдийн засгийн ухааны доктор, академич бол монголын тоймч Ц.Мөнхбаатар, Б.Дашзэвэг нар доктор, Б.Дүгэр, В.Базарваань нар МСХ-ны шагналт сэтгүүлчид юм” гэжээ /мөн толийн 464-465 дахь тал/.

Харин яагаад ч юм энэхүү нотолгоо баталгаагаа редактор хэмээх мэргэжил дээр хэрэглээгүй нь гайхал төрүүлэв. Миний мэдэхээс Монголын сэтгүүл зүйн салбарт Өвгөөдэй хэмээх Цэндийн Дамдинсүрэн, доктор Лодонгийн Түдэв, Баарангийн Пүрэвдаш, МСНЭ-ийн Цэндийн Намсрайн нэрэмжит шилдэг редакторын шагналт, сэтгүүл зүйн магистр Ядамжавын Сумьяа зэрэг нэрд гарсан цөөнгүй редакторууд бий. Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл редактор хэмээх мэргэжлийн ач холбогдлыг онцгойлон үнэлж Монголын Сэтгүүлчдийн Холбооны дарга, “Үнэн” сонины Ерөнхий эрхлэгчээр хорь гаруй жил тасралтгүй ажилласан, БНМАУ-ын Төрийн шагналт /Нийгмийн ухааны сонгодгуудын түүврийг гарамгай редакторласны учир уг шагналыг хүртсэн/, Соёлын гавьяат зүтгэлтэн Цэндийн Намсрайн нэрэмжит шилдэг редакторын шагналыг буй болгожээ. Өнгөрсөн хугацаанд уг нэр хүндтэй шагналыг хүртсэн хэд хэдэн сэтгүүлч

редактор бий. Олон улсын тоймч хэмээх ухагдахууныг тольд тайлбарлаж тодорхойлохдоо зохиогч энэ салбарын төлөөллийг нэр дурдсаны нэгэн адил редактор хэмээх ухагдахуунд буух эзэн, буцах хаягтайгаар хандсан бол улам л илүү үнэмшилтэй болох байжээ. Жишээ нь МСНЭ-ийн Цэндийн Намсрайн нэрэмжит шилдэг редакторын шагналт Я.Сумьяа гэхэд тус улсын түүхэнд анх удаа бүтээгдсэн “Монголын нэвтэрхий толь” /2000/ 2 ботийг хэвлэлд шилжүүлэх сигналын эхийг уншин хянаж, сүүлд нэмж баяжуулж хэвлүүлсэн “Монголын үндэсний нэвтэрхий толь”-ийн 3 ботийг бэлтгэх редакцийн хэсэгт ажиллаж эх бэлтгэлийг гардан гүйцэтгэсэн байдаг юм. Монгол Улсын ШУА монголын сэтгүүлчдийг төлөөлүүлэн түүнийг нэр заан урьж нэвтэрхий толь дээрээ суулгаж ажиллуулжээ гэсэн үг. Гарцаа нь үгүй шилдэг редактор мөн. Гэтэл түүний нэр энд алга, “Нэвтэрхий толь”-д орсонгүй.

Хэдий тийм боловч Монголын сэтгүүл зүйн үндэслэгчдээс эхлээд үеийн шилдэг нийтлэлчийг “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-д боломжит хэмжээнд багтаасан нь уг толь бичгийн нэг томоохон давуу тал мөн бөгөөд хамрагдсан тоо хэмжээ, агуулга далайцаараа өмнөх толиудаас тохой өндөр болжээ гэж бүрэн итгэлтэй хэлж болно. Энэ онцлог нь Л.Норовсүрэнгийн нэвтэрхий толийг өнгөлөн чимж онцгойруулан ялгаруулж байна.

**Монголын сэтгүүл зүйн салбарын үе үеийн төлөөллийн талаар. Бадрахбаатар Д /1849-1922/.** Монголын ууган тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинуудын ажилд идэвхтэй оролцож, монголын нийтлэлийн илчлэн шүүмжлэх чиглэлийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн нэрт сэтгүүлч... Язгууртан гаралтай, төрийн алба хашдаг хүн хэдий ч, шулуун шударга зантай, аливаа асуудал дээр жирийн ард олны эрх ашгийг эрхэмлэдэг, дэвшилт ардчилсан үзэлтэй, тухайн үеийнхээ тэргүүний сэхээтнүүдийн нэг байв.

Д.Б. ард иргэдээс хохирч хэлмэгдсэн тухай дээдэстэй хийсэн зарга тэмцлийг дэмжиж, өргөдөл гомдлыг нь хууль зүйн үндэслэл сайтай бичиж өгдөг, түүгээр өргөдөл бичүүлж заалдсан хүмүүс гол төлөв заргаа авдаг байснаас “Болдоггүйг болгодог хүн” хэмээн олонд талархагдаж байжээ. Түүний голч шударга шүүмжлэлийг жирийн иргэд талархан таашааж байхад, эрх баригч хүчнийхэн “ховын сайд”, “нохойбаатар” гэх мэтээр хочилж эгдүүцэн дургуйцаж байжээ...

Д.Б. “Шинэ толь хэмээх бичиг”-ийн Засгийн газрын “мэдээ, сонсгол, Автономитын дээд, доод хурлын тухай материалыг дагнан хариуцаж бичдэг байв” /мөн толийн 78-79 дэх тал/.

“**Бодоо Д.** /1885-1922/ Монголын үндэсний сэтгүүл зүйн эхлэлийг тавьсан “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинуудад ажиллаж, гол нийтлэлүүдийг бичиж байсан сэтгүүлчдийн нэг, төр нийгмийн зүтгэлтэн... гэрээр орос, хятад, манж, төвд хэл бичиг сурч, улмаар Шанзавын яаманд бичээч болсноор амьдралын гараагаа эхэлжээ.

Д.Б Консулийн дэнжийн хувьсгалт нууц бүлгэмийн ажилд идэвхтэй оролцож, 1920 онд Зөвлөлт Орос улсаас тусламж гуйх төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтаж, хувьсгалын үйл хэрэгт тууштай зүтгэсэн эх оронч сэхээтэн байв... Нийслэл хүрээг чөлөөлсний дараа Засгийн газрын ерөнхий сайдаар томилогджээ.

Д.Б “Шинэ толь хэмээх бичиг”-ийн дотоодын эдийн засаг, сургууль, соёлын сэдэвтэй шүүмжлэлт өгүүлэл, иргэний нийтлэлийг хариуцан бичдэг байсны дээр Харбинд гарч байсан “Монголын сонин бичиг”-т улс орны хөгжилд саад болж байсан феодалын байгууллын хүнд суртал, хоцрогдлыг илчлэн шүүмжилж, шашин лам нарын дотор шинэчлэлт хийхийг эрмэлзэн дэвшилт үзэл санаа бүхий нийтлэлүүдийг гаргаж байв. Тэрээр хурц шүүмжлэлт нийтлэлээ “Болд-Илд” гэх нууц нэрээр гаргадаг байсны дээр Ж.Цэвээнтэй хамтран “Хоршооны дүрэм” боловсруулж Автономитын дээд, доод хуралд оруулж байжээ.

Д.Б “Нийслэл хүрээний сонин бичиг”-т гаргасан “Эсэргүүцэл” гэсэн гарчигтай цуврал нийтлэлийн заримыг бичжээ /мөн толийн 95-96 дахь тал/.

**Цэвээн Ж.** /1881-1942/. Монголын сэтгүүл зүйг үндэслэгч, анхны сонины эрхлэгч, нийгэм улс төр, шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, Шинжлэх ухааны хүрээлэнгийн жинхэнэ гишүүн, доктор / ScD/...

Ж.Цэвээний гавьяат үйлсийн нэг нь Монголын үндэсний сэтгүүл зүйг үндэслэн байгуулсан явдал мөн. Тэрээр өмнө нь Харбинд гарч байсан “Монголын сонин бичиг” сонины Монгол дахь сурвалжлах товчоонд ажиллаж байсан туршлагадаа тулгуурлан 1913 онд Монголын ууган тогтмол хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” сонинуудыг эрхлэн гаргаж, зонхилох нийтлэлүүдийг бичиж нууц нэрээр гаргаж байв.

Ж.Ц Монголын сэтгүүл зүйг үндэслээд зогсоогүй, түүний бичлэгийн төрөл, зүйлийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан /мөн толийн 575-576 дахь тал/.

Монголын сэтгүүл зүйг үндэслэгч, түүний хамтран зүтгэгчдийн талаарх нэр бүхий гурван сэтгүүлчийн талаар нэвтэрхий тольд зохиогчийн оруулсан хэсгээс зориуд иш татаж онцоллоо. Энэ нь танин мэдэхүйн онцгой ач

холбогдолтой юм. Учир нь өнөөгийн зарим залуу сэтгүүлч үүнийг төдийлөн мэддэггүй юм. МСНЭ-ийн тэргүүн зэргийн шагнал нь Жамсраны Цэвээний нэрэмжит уран бүтээлийн дээд шагнал. Бас Бодоогийн нэрэмжит тусгай шагнал бий. Монголын сэтгүүлчдийн нэг их хурал дээр тээр жил өөрийгөө ихэд тоож өргөмжилсөн залуу хөвгүүн босч ирээд намайг МСНЭ-д 1921 оны ардын хувьсгалын анхны ерөнхий сайд Бодоогийн нэрэмжит шагнал бий болголоо, сэтгүүл зүйн цагаан толгойн А-ч үгүй хүнийг намчирхаж тус салбарт хүчээр чирж авчирлаа хэмээн учиргүй загнаж билээ. Тийм хүмүүсийн нүдээр харах юм бол хошой гүн Бадрахбаатар гэхэд мянган малтай феодал л харагдана.

2021 онд монголын сэтгүүл зүйн нэр бүхий хоёр ч докторын судалгааны ном хэвлэгдсэн. Тэдгээрт Монголын сэтгүүл зүйг үндэслэгч нь ганц Цэвээн биш, Нийслэл хүрээн дэх хаант Оросын ерөнхий консул Коростовец голлох гавьяатай гэж баталцаасан билээ. Уг мэтгэлцээнд миний бие татагдан оролцож “Нэгэн жарны сударласан сургамж” /УБ.2022/ номондоо “Үндэсний сэтгүүл зүйг үндэслэгч нь Жамсраны Цэвээн үү, эсвэл залхаалт бодлогоо тулган хүлээлэгч Коростовец үү?” хэмээх нэртэй судалгааны ажлаа оруулж баримт нотолгоотойгоор уг эндүүрлийг няцаасан, би хэрэв андуураагүй бол Л.Норовсүрэн ч МУИС-ийн “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний бичигт өгүүлэл бичсэн санагдаж байна. Энэ тухай үг, өгүүлбэр түүний Нэвтэрхий тольд бараг алга. “Монголын анхны тогтмол хэвлэлийн түүхэн судалгаа” хэмээх толгойн гарчигт М.Одмандахын бичсэн энэ ном “Монголын ууган үйлдвэрийн түүхийг тодруулах асуудалд”, “Шинэ толь хэмээх бичиг” гэсэн хоёр бүлгийн хүрээнд анхны хэвлэх үйлдвэрийн тухай судалгааны тойм, хэвлэх үйлдвэр байгуулах үүсгэл, санаачилга, хэвлэх үйлдвэрийг бэхжүүлэхэд И.Я.Коростовецийн хувь нэмэр, хэвлэх үйлдвэр байгуулахад Ж.Цэвээний оролцоог хөндсөн байна.

Түүнчлэн гадаад орнуудаас монголчуудад зориулан гаргасан сонинуудын тухай, сонин гаргах санаачилга ба И.Я.Коростовецийн хүчин зүтгэл, сонин хэвлэгдсэн түүхэн үнэн ба Ж.Цэвээний оролцоо, “Шинэ толь хэмээх бичиг” сонины он цагийг тодруулах зэрэг асуудлыг авч үзжээ” /мөн толийн 214-215 дахь тал/ гэсхийгээд орхижээ.

Монголд анхны хэвлэх үйлдвэрийг байгуулсантай холбогдуулж надад маргах зүйл байхгүй, хэвлэлийн мэргэжлийн эрдэмтэн судлаачид нь өөрсдийн үгийг хэлчихсэн байгаа. Харин “Шинэ толь хэмээх бичиг” сониныг үүсгэн байгуулагчийн асуудлаар бол бий, түүнийгээ ч удаа дараа ил тодоор ямар ч хоёрдмол утгагүйгээр илэрхийлж үзэл бодол, байр сууриа баталгаа нотолгоотойгоор хамгаалж ирсэн билээ.

“Хэвлэх үйлдвэртээ түшиглэн монголчуудад зориулсан сонин гаргах ажлыг зохион байгуулсан хүн нь И.Я.Коростовец мөн болох нь судалгаагаар

тогтоогдож байгаа тул түүнийг санаачлагч, үндэслэгчдийн нэг хэмээн үзэх бүрэн үндэстэй байна...

Тиймээс манай судлаачдын өмнө нь үздэг байсан шиг Ж.Цэвээн ганцаараа идэвхийлэн зүтгэж байж, анхны тогтмол хэвлэлийг байгуулсан гэсэн дүгнэлт нь өрөөсгөл бөгөөд хамтран ажиллаж, идэвхи санаачилга гаргаж, хөрөнгө санхүүг гаргаж, эрхлэн хэвлүүлсэн И.Я.Коростовецийн түүхэн үүргийг үгүйсгэх аргагүй бөгөөд дээрх хоёр эрхмийг /Ж.Цэвээнийг хамтатгаж буй Т.Б/ хамтад нь “Шинэ толь хэмээх бичиг” сониныг үүсгэн байгуулагчид, үндэслэгчид нь мөн гэсэн дүгнэлтийг хийж байна” гэж доктор М.Одмандах бичсэн бол / М.Одмандах. Монголын анхны тогтмол хэвлэлийн судалгаа. УБ. 2021. 159-160 дахь тал/, 1920 оны “Монголын үнэн” сониныг монголчуудын гаргасан хэвлэл биш ОК/б/Н, Коминтерний хэвлэл гэж үзсэн доктор Б.Галаарид 2021 онд хэвлүүлсэн “Монголын үнэн” сонины бодит түүх” номондоо “Монголд 1913 онд “Шинэ толь хэмээх бичиг” хэвлэлийг үүсгэж гаргасан хүн нь И.Я.Коростовец болохыг доктор М.Одмандах баталгаажууллаа, энэхүү гавьяа зүтгэлийг зохих ёсоор үнэлж, түүхэн байр суурийг эзлүүлэх нь шударга ёсонд нийцнэ...” гэх зэргээр өгүүлсэн нь бий. Эсрэг тэсрэг энэ мэт үзэл бодол өнөөдөр Монголд бодитойгоор оршин тогтнож байгаа нөхцөлд тэдгээрийг Толь бичигт товч боловч тусгаж зөв өнцгөөс тайлбарлан таниулж байх нь илүүдэхгүй буй заа.

**Цаашид анхаарах зарим зүйлсийн талаар.** Л.Норовсүрэнгийн “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-ийг гүйлгэн харж, сонирхол татсан толгойн тодорхойлолтуудыг шимтэн уншиж үзэхэд орхигдож гээгдсэн хийгээд буруу ташаа буюу дутуудуулсан зүйл мэр сэр тааралдаж байгааг эрх биш хэлэх нь зүйтэй буй заа. Энэ нь сэтгүүл зүйн онол, түүхийн арга зүйн үндсэн ойлголтуудыг хураангуйлан багцалсан нэвтэрхий толь бичиг зохиох анхны оролдлого тул гайхах юмгүй. Зохиогч өөрөө ч үүнийгээ учирлаж “эндүү ташаа дүгнэж тодорхойлсон зүйл байж болзошгүй тул толь ашиглагчид өөрсдийн мэргэн ухаанаар шүүн тунгааж, санал бодол, шүүмж зөвлөгөөгөө харамгүй хайрлахыг хүсч байна” /мөн толийн Зохиогчийн үг, 5 дахь тал/ гэжээ.

Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагт 15 жил ажилласан надад гэхэд л “Агентлаг” хэмээх үгийн үндсэн агуулга, утга ухагдахуун нэхэгдэж байгаа юм. Шинэ Монгол Улсын түүхэнд үүсч буй болсон анхны мэдээллийн агентлаг нь МОНТА буюу МОНЦАМЭ, 1921 оны 7 дугаар сарын 19-нд үүсээд өнөөдрийг хүртэл оршин тогтнож дотоод, гадаад мэдээлэл түгээж иржээ. Гэтэл нэвтэрхий толийн толгойн үсгийн гарчигт “Агентлаг” хэмээх үгийг сэтгүүл зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарласан тодорхойлолт алга, үгүйлэгдэж байна. Үүнийг онцолдог учир гэвэл сүүлийн жилүүдэд

Үндэсний олон нийтийн төв телевизийн “Цагийн хүрд” өөрийгөө агентлаг гэж нэрлэх болсон. Хувийн хэвшлийн “Гамма” хэмээх фото агентлаг ч гарч ирсэн. Агентлаг хэмээх үг хэд хэдэн утгаар хэрэглэгдэж, янз бүрийн агуулгыг илэрхийлдэг нь ойлгомжтой юм. Төр засгийн чиглэлийн тохируулагч болоод чиглүүлэгч тусгай агентлагууд ч гэж бий. Хэдий тийм боловч хүн төрөлхтөн, улс орнуудын түүхэнд мэдээллийн агентлаг гэсэн нэр томъёо нэгэнт хэвшиж тогтоод тодорхой ойлголт, үндсэн агуулга нь хадгалагдсаар байгаа. Түүнийг ямар үндсэн шалгуур үзүүлэлтээр ялгаж салгаж тодорхойлж болохыг “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-д тусгаж өгөх зайлшгүй шаардлагатай байж, тэгвэл улам л утга төгс болох юм.

Манайд өөрсдийгөө сонин хэвлэлд “Олон улсын сэтгүүлч Б.Дашзэвэг” гэх зэргээр бичиж тэмдэглэх нь элбэг. Монголын сэтгүүлчдийн байгууллага Брюссельд төвтэй ОУСБ-ын гишүүн мөн, тийм учраас зарим уран бүтээлчдэд гадаадын улс оронд сурвалжлах ажлаар явахад нь мэргэжлийн үүднээс тус нэмэр үзүүлэх зорилгоор өнгөрсөн зууны ерээд он, хоёр мянган оны эхээр ОУСБ-ын тэрхүү үнэмлэх бичгийг нэг хэсэг хувь хүмүүст шийтгэж олгож байсан явдал бий. Тэр нь МСНЭ бол ОУСБ-ын гишүүн байгууллага шүү гэдгийг сануулж хэлж байгаа болохоос биш тухайн хүнийг олон улсын сэтгүүлч хэмээн тодорхойлж байгаа хэрэг хараахан биш юм. Өөрсдийгөө олон улсын сэтгүүлч гэж хэвлэлд бичиж буй тэр хүмүүсийг буруутгах аргагүй, үнэмлэхтэй болсноор олон улсын сэтгүүлч болчихлоо гэж бодож буй хэрэг. Харин учир начрыг хэлж өгөх хэрэгтэй юм. Олон улсын сэтгүүлчийг эрх бүхий хүлээн зөвшөөрөгдсөн өндөр нэр хүндтэй мэргэжлийн их, дээд сургуулиар тусгайлан сургаж бэлтгэдэг. Дор хаяхад л түгээмэл хэд хэдэн гадаад хэлээр ярьж нэвтрэлцэж чаддаг, хамгийн гол нь бичгийн англи хэлтэй байх зайлшгүй шаардлагатай. Олон улсын амьдралын тулгамдсан чухал сэдвүүдээр сонин сэтгүүл, мэдээллийн агентлагт олон жилийн турш тасралтгүй дагнан бичиж, дэлхий дахинд нэрд гарч танигдаж алдаршсан сэтгүүлч ганц нэгхэн бий, тэднийг олон улсын хэмжээний сэтгүүлч гэж хүндэтгэж хүлээн зөвшөөрч нэрлэх нь бий.

Нэвтэрхий толийн зохиогч Олон улсын тоймч хэмээх үгийн агуулгыг тодорхойлсон атлаа Олон улсын сэтгүүлч гэж хэнийг хэлэх вэ гэдгийг орхигдуулжээ. Гэтэл өөрийгөө олон улсын сэтгүүлч болчихсон гэж үздэг хүмүүс өнөө хэр Монголд байсаар байгаа юм. Энд би манай практикт үе үе тохиолдож буруу зөрүү ойлгогддог нэр томъёоны талаар ярьж буйг зөвөөр ойлгоно буй заа.

Үүн дээр нэмж нэг зүйлийг хэлье. “Монголын шилдэг нийтлэл” цуврал 99 боть 2010 оноос тасралтгүй үргэлжлэн хэвлэгдсээр өнөөг хүргэсэн. Нэг зуун арав гаруй жилийн түүхтэй монголын сэтгүүл зүйн үе үеийн шилдэг

сэтгүүлчдийн уран бүтээлийн цоморлигууд. “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-д өөрийн байр суурийг эзлэх зайлшгүй шаардлагатай сэдэв гэдэгт би хувьдаа өчүүхэн ч эргэлзэхгүй байна. Гэтэл орхижээ. Доктор, профессор Ломбын Норовсүрэн бол өөрөө тус цувралын редакцийн зөвлөлийн нэг гишүүн нь юм. Маргана гэж яавч байхгүй. Өөр толь бичигт орохгүй, дурдагдахгүй өнгөрч болно. Харин “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-д бол арай ч дээ л гэж бодогдсон. Уучилж болшгүй алдаа л гэж хэлмээр санагдаад байгаа юм. МУИС-д сэтгүүл зүйгээр мэргэшсэн Эрдмийн зөвлөл байгуулагдаж үндэсний эрдэмтдийг бэлтгэж эхэлсэн талаарх мэдээлэл алга.

Толийн зохиогч “Монголын сэтгүүлчдийн байгууллага сэтгүүлчдээр мөрдүүлэх ёс зүйн зарчимтай болох оролдлогуудыг хэд хэдэн удаа хийж ирсэн байдаг. Анх 1990 оны 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд болсон Монголын сэтгүүлчдийн VI их хурлаас “Монголын сэтгүүлчдийн эрхэмлэх зарчим” гэдэг баримт бичгийг баталснаар уг үйл хэрэг эхэлжээ” /мөн толийн 226 дахь тал/ гээд цааш нь үргэлжлүүлж эл сэдвийг гүнзгийрүүлэн тодотгосон байна. Энд бяцхан алдаа гарчээ. Хэд хэдэн оролдлого хийсэн гэдэг нь үнэн, гэхдээ анхных нь 1990 онд биш. 1989 онд миний бие МСХ-ны орлогч даргаар ажиллаж байхдаа ОУСБ-ын ёс зүйн кодекс болон АНУ-ын Сонинуудын холбооны ёс зүйн зарчмыг харж судалж, МОНЦАМЭ агентлагийн орчуулагч П.Шагдараар монгол хэл рүү хөрвүүлэг хийлгүүлж “Сэтгүүлч” зэрэг хэвлэлд нийтлүүлж байгаад, тус байгууллагын уран бүтээлийн зөвлөлийн эрхлэгч Бажуудайн Ганбаттай хамтран сууж “Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим”-ын төслийг боловсруулаад МСХ-ны 1989 оны ээлжит бүгд хурлаар хэлэлцүүлэн батлуулж байсан билээ. Тэр оны “Сэтгүүлч” сэтгүүл, мөн “Үнэн” сонинд бүрэн эхээрээ нийтлэгдсэн байх учиртай.

МСХ-ны орон тооны орлогч даргаар олон жилийн турш ажилласан ахмад даргын нэг Д.Үржинбадам өөрийн бичсэн “Монголын сэтгүүлчдийн байгууллагын түүхэн замнал” номондоо энэ тухай тэмдэглэсэн байдаг. Сүүлд 2011 онд уг номыг зарим шинэлэг мэдээ мэдээллээр нэмж баяжуулаад “Монголын шилдэг нийтлэл” цувралын 17 дахь боть болгож хоёр дахь удаагаа хэвлүүлсэн. “Монголын сэтгүүлчдийн байгууллагын түүхэн замнал” нэртэй уг номын 66 дахь талд “Монголын Сэтгүүлчдийн V, VI их хурлын хооронд 1989 онд болсон МСХ-ны Хорооны II бүгд хурал “Өөрчлөн байгуулалтын үе дэх хэвлэл мэдээллийн газрууд, сэтгүүлчдийн байгууллагын үндсэн чиглэл”, “Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим” ... зэрэг асуудлыг тус тус хэлэлцэн зохих шийдвэр гаргаж байсан юм” гэжээ.

Л.Норовсүрэнгийн “Нэвтэрхий толь”-ийн “Шо Фаны өдрийн сэтгүүл” толгойн үгэнд уг сонины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байх

агаад “Сонин 1919 оны 6 дугаар сараас эхлэн өдөр тутам 23х29 см-ийн хэмжээтэй, зургаан нүүртэйгээр 1919 оны 11 дүгээр сарын 1 хүртэл 153 дугаар гаргажээ. Сониныг хятад, монгол үсгээр өдөр бүр хавсран гаргах бодолтой байсан боловч хятад үсэг ирж амжилгүй байсаар гаралт нь зогссон байна” гэжээ /мөн толийн 600 дахь тал/.

Энд цаг хугацааны эндүүрэл гарсан бололтой. Улсын төв номын санд хадгалагдаж буй дээрх сонины дугааруудаас үзвэл 1919 оны 11 дүгээр сарын 1-нд хэвлэлт нь зогссон гэдэг буруу аж. Ингэж хэлэхийн учир нь миний бие “Дундад иргэн улсын есдүгээр он. Долоон сарын нэгэн гэж огноолсон /Энэ нь 1920 оны 7 дугаар сарын 1-ний өдөр юм/, уйгаржин монгол бичгээр 4 нүүрээр хэвлэгдсэн “Шо Фаны өдрийн сэтгүүл” сонины нэгэн дугаарын тухай” хэмээх өгүүлэл бичиж өөрийн номонд бүрэн эхээр нь оруулсан /Лэгсрэн овогт Тугалхүүгийн Баасансүрэн. Сэтгүүл зүйн шүүмж судлал, телевизийн хөтөлбөрийн судалгаа. УБ. 2021. 249-257 дахь тал/. Уг сэтгүүлийг өдөр тутам нэг хуудсаар хятад, монгол үсгээр дармалдан гаргана. Хятад үсгээр хэвлэх машин техник замдаа ирж яваа тул энэ удаад зөвхөн монгол үсгээр дарамлан гаргаж буйг сонсгон мэдээлж байна гэж 1-р нүүрэндээ бичсэн байв. Бүх нүүрт үнэ ханшийн зарлал мэдээлэл, захирамж тушаал нийтлэгджээ. Дотоод гадаадын цаг үеийн мэдээлэл бараг туссангүй. Сар бүрийн захиалгын үнэ 60 мөнгө, хагас жил 3 төгрөг. Нэг жил 5 төгрөгөөр зарж борлуулж байжээ. Ямар ч байсан “Шо Фаны өдрийн сэтгүүл” хэмээх нэртэй тэр сонин 1920 оны 7 дугаар сарын 1 хүртэл нийслэл Хүрээнд гарч байсан байна.

**Мэргэн Х.** /1957-2018/. Энэхүү толгойн үсгийн гарчигт “”Х.М “Миний генерал” I,II анги, “Титаник, “Цахлай”, “Матар хочит Данди”, “Ах дүү Карамазовынхан”, “Мэргэн буучид”..., “Торгуулийн суман”, “Сталинград”” зэрэг телевизийн уран сайхны 500 гаруй кино орчуулжээ /мөн толийн 261 дэх тал/ гэх буюу **“Шынай.Р.** /1944/ Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч, зохиолч Рахметын Шынай Баян-Өлгий аймгийн Өлгий хотод төрсөн” /мөн толийн 604 дахь тал/ гэх зэргээр дурджээ.

Хасбаатарын Мэргэний намтар, уран бүтээлийг эмхэтгэж 2025 онд хэвлэлд шилжүүлсэн “Монголын шилдэг нийтлэл”-ийн 20 дугаар ботиос үзвэл /түүний өөрийнх нь бичиж үлдээсэн/ тэрбээр телевизийн баримтат болоод уран сайхны 700 гаруй кино орчуулсан байх бөгөөд /Дан уран сайхны кино биш, баримтат болоод уран сайхны кинонууд нийлээд Т.Б./, МУСГЗ сэтгүүлч Р.Шынай эдүгээгээс хоёр жилийн өмнө Монгол Улсын Ардын уран зохиолч цол хүртсэн байх жишээтэй байна. Өөрөөр хэлбэл тэдний намтар түүхэнд зайлшгүй тодоор тэмдэглэгдэж байх учиртай зарим тоо баримт, цол гуншинг дутуудуулжээ гэсэн үг юм. Үүнийг өчүүхэн жижиг яль шальгүй зүйл гэж үзэж болохгүй. Яагаад гэвэл “Монголын сэтгүүл зүйн

нэвтэрхий толь”-д оруулж байгаа учраас тэр. Толийн зохиогч хуучирсан тоо баримтыг ахин дахин магадалж, болж өгвөл өөрийн бүтээлээ хэвлэлд шилжүүлсэн 2025 оны цаг мөчийн шинэлэг агуулга баримтаар баяжуулж хөдөлшгүй болгосон байх үүрэгтэй юм.

“Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-д манай салбар шинжлэх ухааны онол, практикийн асуудлаар бүтээгдсэн нэг сэдэвт зохиол, судалгаа шинжилгээний чиглэлээрх эрдэм шинжилгээний даацтай өгүүллүүд, бие даасан ном зохиолуудын агуулга үндсэндээ багтаж чаджээ. Нэвтэрхий толийн нэг том ололт яах ч аргагүй үүгээр тодорхойлогдоно. Ийм өргөн дэлгэр мэдээлэл бүхий лавлагааны хураангуйлсан цоморлиг урьд нь нэг ширхэг ч гарч байгаагүй болно. Үүгээрээ сэтгүүл зүйн онол ухагдахууны төдийгүй практикийн чухал ач холбогдолтой бүтээл болжээ. Сэтгүүлчид, судлаачдын өдөр тутмын хэрэгцээг хангасан ширээний ном болно гэж цохон тэмдэглээд буйн нэг учир энэ юм.

Гэхдээ зарим нэг номын нэр усан дээр дутуу тэмдэглэсэн алдаа мадаг бас харагдана лээ шүү, засаж залруулаарай миний нөхөр. Доктор Д.Отгонбаярын туурвисан “Чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Монголын төрөөс хийж хэрэгжүүлсэн зарим алхам: үр дүн ба сургамж” /УБ. 2023/ номын нэрийг толийн 590 дэх талд “Чөлөөт хэвлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Монголын төрөөс хийж хэрэгжүүлсэн зарим алхам” /УБ. 11,2 хх/ гэж нэрийг гүйцэд биш дутуу тэмдэглэсэн. /Уг номын редактор нь би өөрөө учраас мэдэж буй хэрэг/, миний өөрийн 2021 онд хэвлүүлсэн “Ерөнхийлөгчийн тод мөр, том толбо”-ыг “Ерөнхийлөгчийн тод мөр” хэмээн мөн адил товчилсон байх жишээтэй. Монгол Улсын түүхэн дэх таван Ерөнхийлөгчийн талаарх шинжлэлт нийтлэлийн уг номонд би зөвхөн тэдний гавьяат тод мөрийг товойлгон гаргаад орхиогүй бас өөрийн хэр чадлын хэмжээнд алдаа дутагдалтай үйл ажиллагаанд нь ажиглалт хийж шинжлэхийг оролдсон ухаантай юмаа.

Энэ мэт бага сага дутагдал доголдол Толь бичигт ажиглагдлаа. Мэдээж доктор Л.Норовсүрэн “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-ио энэ хэвээр нь орхихгүй байх, өөрчилж шинэчилж баяжуулаад дахин хэвлүүлж таарна. Түүнд нь өчүүхэн ч атугай тус нэмэр болж юу магад гэсэн /үйлс зорилго нэгт судлаачийн хувьд/ чин сэтгэлийн үүднээс өгүүлж буй минь энэ билээ. Болгоон тунгаана буй заа гэдэгт гүнээ итгэнэм.

### **Үндсэн дүгнэлт**

Дээр дурдсан бүхнийг хураангуйлан базаж үнэлж дүгнэх юм бол дорхи зүйлийг хэлж болохоор байна. Үүнд:

**Нэг.** Доктор Ломбын Норовсүрэн урьд өмнө нь монголын сэтгүүл

зүйн түүхэнд өөрийн шинжлэх ухааны онол, түүх судлалын тулгамдсан асуудлаар хамгийн олон буюу “Сэтгүүл зүй” хэмээх 21 боть зохиол туурвисан гэж бичигдэж байсан бол өнөөдөр Монголдоо анх удаа “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь” бүтээсэн эрдэмтэн хэмээн тэмдэглэгдэх түүхэн том үйлийг бүтээлээ. Нэвтэрхий толь бичнэ гэдэг бол нэг хүний хийх ажил биш, гэвч Ломбын Норовсүрэн үүнийг хийж чадсан байна. Нэг насных нь бүтээлч хөдөлмөр зүтгэлийн үр дүн гэж үзэж болно. Засагт ханы хөх харчуудаас засаршгүй хөдөлмөрчөөрөө товойж тодорсон энэ судлаач өөрийгөө монголын сэтгүүл зүй дэх олон давтагдахгүй онцгой содон авьяастан, онолч, түүхч оргил эрдэмтэн мөн гэдгээ ахин нэгэнтээ нотлон харууллаа.

**Хоёр.** Л.Норовсүрэнгийн “Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь”-д сэтгүүл зүйн онол, практикт өргөн хэмжээгээр тогтвортой хэрэглэгдэж буй тулгуур ухагдахуун, нэр томьёо, ойлголтуудыг А-Я хүртэлх Цагаан толгойн үсгийн дэс дараалалд оруулж 1641 үгэнд багтаан тайлбарлаж, тодотгож тодорхойлсон нь шинжлэх ухаан, танин мэдэхүйн өндөр үнэ цэн бүхий, нийт сэтгүүлчид, судлаачдын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах практик ач холбогдолтой чухал бүтээл болсон байна. Монголын сэтгүүл зүйн сургалт, судалгаа шинжилгээ, мэдээлэл зүй дэх ширээний ном нэгээр нэмэгдлээ гэж хэлж болно.

### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

Ломбын Норовсүрэн. *Монголын сэтгүүл зүйн нэвтэрхий толь*. УБ. 2025

### **Summary**

This article introduces the newly published *Encyclopedia of Mongolian Journalism* authored by renowned journalism professor Lombo Norovsuren, Professor and one of the most influential figures in Mongolian media studies. Over the course of his academic career, Dr. Norovsuren has published 64 books, authored 67 scholarly articles, presented 35 academic papers, and reviewed and edited 51 works by other authors, making a significant contribution to the development of journalism research in Mongolia. A landmark achievement in his scholarly legacy is the publication of the 21-volume series *Journalism* in 2019, which set a national record as the largest multi-volume academic work produced within a single scientific discipline in Mongolia. The newly released encyclopedia represents a comprehensive synthesis of Mongolian journalism's history, theory, key concepts, institutions, and practitioners, and constitutes an important reference work for researchers, educators, students, and media professionals.

Keywords: mongolian journalism, encyclopedia of mongolian journalism, Lombo Norovsuren, mongolian media studies, journalism research in Mongolia, media scholarship, journalism education, journalism theory, journalism history, media professionals, academic publications, scholarly contributions, journalism encyclopedia, media institutions, journalism practitioners, Mongolian press history, communication studies, academic legacy, journalism in Mongolia, multi-volume academic work, journalism scholarship, media research, journalism reference work, Mongolian academia, journalism studies, encyclopedia publication, media education, journalism concepts, journalism scholars, Mongolian intellectual history